



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

9
АНГИ

МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 21 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Өчүүхэн таслалаар хүний амийг аварч болно

Оргүй хоосноос олон утга цацарна. Ямар нэг юм байна гэдэг нэгийг хэлдэг шиг, байхгүй байна гэдэг ч өөрийг хэлнэ. Тухайлбал, малгай нь өлгүүрт байвал ажилтан нь ажилдаа байгааг, хоосон байвал гэртээ харьсныг илтгэдэг гэсэн утгатай. Мөн тооны тэг ч бас чухал үүрэгтэй. 0025, 2005, 2500, 2050 гэхчлэн хөөрхий муу тэгүүд олон утга илтгэж байна. Үүнчлэн яруу тансаг найруулгаар цэцэн цэлмэг ярихад хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс илүү ихийг хэлж байгаа хэрэг. Тэгээд ч “Үгийн олноос үхрийн олон”, “Үг олдож үхэр холдлоо”, “Үг давтал улг”, “Ярихаар яв, хэлэхээр хий” гэх зэргээр хэлэлцдэг.

Ярианыхаа дунд үг, өгүүлбэрийн хооронд түр азнах, чимээгүй болохыг хэлэнд “зогсоц” гэнэ. Д.Батбаяр зогсцыг “түдэц” гэж нэрлэжээ. Энэ нь “удаж, түдэх” гэсэн утгаас үүссэн аж. Ярианыхаа хамгийн чухал үг, хэлэх гэсэн гол санааныхаа үед бусдын анхаарлыг төвлөрүүлж, ёстой ялаа нисэх нь сонстом чимээгүй болгоод яриагаа үргэлжлүүлэх нь хүмүүст онцгой нөлөөлдөг.

Бичигт зогсцыг таслал, гурван цэг, хоосон зай, зураас зэргээр тэмдэглэдэг. Жишээ нь: “Төмөр, малгай өмсөв. Төмөр малгай өмсөв”, “Хоёр, үстэй дээл. Хоёр үстэй дээл” гэхэд таслал буюу зогсоц ямар их ялгаа илтгэж байна вэ? Түүхэнд ганцхан таслалаар өөрийн амийг аварч байсан тохиолдол нэг биш удаа гарч байжээ. Тухайлбал:

Казнить, нельзя помиловать (Цаазал, өршөөж болохгүй)

Казнить нельзя, помиловать (Цаазалж болохгүй, өршөө)

Ингээд бодоход өчүүхэн зогсоц, таслалыг яриа, бичигт ихэд анхаарч судалж үзэхээс аргагүй ээ.

М.Саруул-Эрдэнэ “Сонирхолтой хэл шинжлэл”

Монгол хэлний даалгаврууд

1. Эхийн бүтцийг утгаар нь зөв дараалуулсныг олоорой.
 - A. яриа бичигт таслалыг анхаарч үзэх тухай, хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс ихийг хэлдэг тухай, “зогсоц” хэмээх ойлголтын тухай
 - B. хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс ихийг хэлдэг тухай, яриа бичигт таслалыг анхаарч үзэх тухай, “зогсоц” хэмээх ойлголтын тухай
 - C. хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс ихийг хэлдэг тухай, “зогсоц” хэмээх ойлголтын тухай, яриа бичигт таслалыг анхаарч үзэх тухай
 - D. яриа бичигт таслалыг анхаарч үзэх тухай, “зогсоц” хэмээх ойлголтын тухай, хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс ихийг хэлдэг тухай



2. Эхний цогцолбороос “Оргүй хоосноос олон утга цацарна” гэсэн зохиогчийн үзэл бодлыг батлах баримтад хамааралгүйг сонгоорой.
 - A. Малгай нь өлгүүрт байвал ажилтан нь ажилдаа байгааг, хоосон байвал гэртээ харьсныг илтгэдэг гэсэн утгатай.
 - B. Ямар нэг юм байна гэдэг нэгийг хэлдэг.
 - C. Мөн тооны тэг ч бас чухал үүрэгтэй. 0025, 2005, 2500, 2050 гэхчлэн хөөрхий муу тэгүүд олон утга илтгэж байна.
 - D. Хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс илүү ихийг хэлж байгаа хэрэг.
3. “Үгийн олноос үхрийн олон”, “Үг олдож үхэр холдлоо”, “Үг давтвал улиг”, “Ярихаар яв, хэлэхээр хий” гэх зэргээр хэлэлцдэгийн учир юу вэ?
 - A. Ямар нэг юм байна гэдэг нэгийг хэлдэг учраас
 - B. Малгай нь өлгүүрт байвал ажилтан нь ажилдаа байгааг, хоосон байвал гэртээ харьсныг илтгэдэг учраас
 - C. 0025, 2005, 2500, 2050 гэхчлэн хөөрхий муу тэгүүд олон утга илтгэж байгаа учраас
 - D. Хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс илүү ихийг хэлж байгаа учраас
4. Эхийн сэдвийг зөв тодорхойлоорой.
 - A. Бичигт зогсцыг хэрхэн тэмдэглэх тухай
 - B. Зогсоц, таслалыг яриа бичигт зөв хэрэглэх тухай
 - C. Хэрэгцээтэй үед дуугүй байх тухай
 - D. Бусдын анхаарлыг өөрийн ярианд хэрхэн төвлөрүүлэх тухай
5. Гол санааг эхээс зөв олж бичсэн нь аль вэ?
 - A. Өчүүхэн зогсоц, таслалыг яриа, бичигт ихэд анхаарч судалж үзэхээс аргагүй ээ.
 - B. Бичигт зогсцыг таслал, гурван цэг, хоосон зай, зураас зэргээр тэмдэглэдэг.
 - C. Ярианыхаа хамгийн чухал үг, хэлэх гэсэн гол санааныхаа үед бусдын анхаарлыг төвлөрүүлэх
 - D. Хэрэгцээтэй үед дуугүй байх нь олон үгээс ихийг хэлдэг
6. Таслал хэрэглэснээр өгүүлбэрт утгын ямар өөрчлөлт гарч байгааг ажиглаад, “Хоёр, үстэй дээл”, “Хоёр үстэй дээл” өгүүлбэрүүдийн утгыг зөв тайлбарласныг олоорой.
 - A. Дээрх өгүүлбэрүүдэд утгын ямар ч өөрчлөлт байхгүй буюу яг адилхан утгатай.
 - B. Дээрх өгүүлбэрүүд харагдах хэлбэрээрээ өөр буюу “таслал”-тай ч утгын өөрчлөлт байхгүй
 - C. Эхний өгүүлбэр: “Хоёр ширхэг үстэй дээл” гэсэн санаа
Удаах өгүүлбэр: “Үстэй дээл хоёр ширхэг” гэсэн санаа
 - D. Эхний өгүүлбэр: “Үстэй дээл хоёр ширхэг” гэсэн санаа
Удаах өгүүлбэр: “Хоёр ширхэг үстэй дээл” гэсэн санаа
7. Таслалыг оновчтой хэрэглэн, “Ханын самбар хоёрыг авсан” гэх санааг зөв найруулан бичсэнийг олоорой.
 - A. Хоёр ханын самбар, авлаа.
 - B. Хоёр ханын самбар авлаа.
 - C. Хоёр, ханын самбар авлаа.
 - D. Хоёр ханын, самбар авлаа.



8. “Д.Батбаяр зогсцыг “түдэц” гэж нэрлэжээ. Энэ нь “удаж, түдэх” гэсэн утгаас үүссэн аж” гэсэн өгүүлбэрийг таамагласан утгат өгүүлбэр болгон бичээрэй.
- A. Д.Батбаяр зогсцыг “түдэц” гэж нэрлэжээ. Энэ нь “удаж, түдэх” гэсэн утгаас үүссэн юм.
 - B. Д.Батбаяр зогсцыг “түдэц” гэж нэрлэжээ. Энэ нь “удаж, түдэх” гэсэн утгаас үүссэн байна.
 - C. Д.Батбаяр зогсцыг “түдэц” гэж нэрлэжээ. Энэ нь “удаж, түдэх” гэсэн утгаас үүссэн болов уу.
 - D. Д.Батбаяр зогсцыг “түдэц” гэж нэрлэжээ. Энэ нь “удаж, түдэх” гэсэн утгаас үүссэн гэдэг.
9. “Малгай нь өлгүүрт байвал ажилтан нь ажилдаа байгааг илтгэдэг” нийлмэл өгүүлбэрийн холбоосыг илрүүлж, ямар утгат өгүүлбэр болохыг тодорхойлоорой.
- A. -вал нөхцөлөөр холбогдсон орны утгат нийлмэл өгүүлбэр
 - B. -вал нөхцөлөөр холбогдсон шалтгааны утгат нийлмэл өгүүлбэр
 - C. -вал нөхцөлөөр холбогдсон цагийн утгат нийлмэл өгүүлбэр
 - D. -дэг нөхцөлөөр холбогдсон шалтгааны утгат нийлмэл өгүүлбэр
10. “Малгай нь өлгүүрт байвал ажилтан нь ажилдаа байгааг илтгэдэг” өгүүлбэрийн “-вал” хэмээх онцолсон нөхцөлийг оновчтой солин найруулж, өгүүлбэрийн утгыг хадгалан бичихэд тохиромжтой холбоос нь аль вэ?
- A. -н
 - B. -ж
 - C. -сан ба
 - D. -снаар

Үндэсний бичгийн даалгаврууд

11. “” бийрээр бичсэн өгүүлбэрийг зөв уншаарай.
- A. Дүрийн сахиус журамт сайд
 - B. Дүрийг сахисан зоригт сайт
 - C. Төрийг сахисан зоригт сайт
 - D. Төрийн сахиус журамт сайд

12. “хөөрхөн” хэмээх үгийг зөв бичсэнийг олоорой.

A.

B.

C.

D.



13. “ᠠᠭᠠᠷ” буюу агаар” хэмээх үгтэй ижил хэлбэрээр бичигдэх үгийг олоорой.

A.

ᠠᠭᠠᠷ

B.

ᠠᠭᠠᠷ

C.

ᠠᠭᠠᠷ

D.

ᠠᠭᠠᠷ

14. “ол+гчи” бүтээврийн нийлцийг зөв бичсэнийг олоорой.

A.

ᠣᠯᠤᠭᠴᠢ

B.

ᠣᠯᠤᠭᠴᠢ

C.

ᠣᠯᠤᠭᠴᠢ

D.

ᠣᠯᠤᠭᠴᠢ

15. “ᠠᠭᠠᠷ” хэмээх үгэнд холбох эгшгийн дүрмээр шууд залган бичих нөхцөлийг олоорой.

A.

ᠠ

B.

ᠠ

C.

ᠠ

D.

ᠠ

Уран зохиолын даалгаврууд

16. Б.Лхагвасүрэн “Боржигоны бор тал” шүлгийн “Чулуун дээр чинь баяр гунигийн нулимс унагахад
Эр хүн шиг нуруутай бай гэсэн юм шиг
Эргүүлж над руу цацан хатуугаас хатуу байсан чи” гэдэгт уран дүрслэлийн ямар арга илэрч байна вэ?

- A. тойруулал
- B. юмшуулал
- C. төлөөлөл
- D. хүншүүлэл

17. Мандухай цэцэн хатны тангаргийн шүлэгт:

“Өргөн их үүдийг чинь хөнгөн гэж
Өндөр их босгыг чинь нарийн гэж
Өөр хүмүүнд эчвээс
Өөд үгүй нэр над хоцормуй
Балчир үрийг чинь бага гэж
Басаж доромжлох үгүй би
Болд унг их гэж
Богтлогдож очих үгүй би” гэсэн нь ямар санааг агуулж байна вэ?

- A. Өвөг дээдсээ хүндэтгэж байна гэсэн санаа
- B. Хааны удмын бэр больё гэсэн санаа
- C. Улсынхаа хувь заяанд зовнисон санаа
- D. Эр нөхөртөө үнэнч эмэгтэй гэсэн санаа



18. Б.Ринчен “Нууцыг задруулсан захиа” өгүүллэгийн “Баруун Монголын Галдан Бошготын цэрэг, Манжийн Энх-Амгалан хааны цэрэгт Туулын Зуун модны газар ихэд дарагдаад Зүүн гар хэмээх Монголын хүчин мохож, ...” хэсэг нь ямар хам сэдэвт хамаарах вэ?
- A. Улс төрийн
 - B. Түүхийн
 - C. Шашны
 - D. Нийгмийн
19. Д.Нямсүрэн “Дөрвөн цаг” шүлгийн
“Ган жийжүү дөрөө гадаа дуугарах сайхан
Ганган морьтой хүн буух сайхан
Намрын сарын шинийн гурван ирэх сайхан
Намуун үдэш аргын тооллын сар гарах сайхан” мөртүүдэд **хамааралгүй** холбоцыг сонгоорой.
- A. Зэрэгцсэн холбоц
 - B. Толгой холбоц
 - C. Салаавчилсан холбоц
 - D. Сүүл холбоц
20. “Чингисийн эр хоёр загалын тууж оршив” зохиолын төгсгөлд : “Сод Богд эзэн бага загалыг найман жил хурлав, найман жил хагсаав.
Намрын тэргүүн сард
Авд мордъё гэж авд мордон
Алтай ханыг арлан авлав
Арван түмэн авын хүмүүн магтан гайхав...
Сод Богд Чингис хаан
Бага загалд хив татаж сэтэрлэв гэлээ” хэмээжээ. Бага загалыг сэтэрлэсний шалтгаан юу вэ?
- A. Бага загал эзэндээ үнэнч сайн морь болохоор
 - B. Бага загалыг их гавьяа бүтээсэн болохоор
 - C. Бага загалыг олон жил уналгүй таргалуулсан болохоор
 - D. Бага загал олны нүдийг булаасан унаа болохоор



Санамж:

- ✓ Хоёрдугаар хэсгийн даалгавар сонгох биш, харгалзуулах даалгавар тул хариултын хуудасны 2-р хэсэгт будаж тэмдэглээрэй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Бичил долгионы зуух

Халаасан хоол хүний биед сайн уу, муу юу? Бидний сайн мэдэх печь буюу бичил долгионы зуухыг зохион бүтээх санааг 1945 онд Percy Spencer хэмээх эрдэмтэн хүчтэй богино долгион ялгаруулдаг магнетрон хэмээх төхөөрөмж дээр ажиллаж байхдаа халаасанд нь байсан шоколад хайлж байхыг хараад олсон байдаг. Бичил долгионы зуухан дотор байдаг долгион нь нүдэнд харагддаггүй 2500 мегагерц орчим давтамжтай байдаг. Зуухны нэг хананд магнетрон хэмээх бичил долгион үүсгэгч төхөөрөмжийг байрлуулаад долгион ялгаруулна. Түүний эсрэг талд болон магнетроныхоо хажуу талд долгион буцаж ойх металл хавтан байрлуулсан байдаг бөгөөд тэр хоёр металлын хооронд бичил долгионыг дахин дахин ойлгож, савлуулна. Өөрөөр хэлбэл ирж, буцаад байгаа долгионууд хоорондоо давхцаж хүчтэй долгион үүсгэж хоолыг халаадаг.

Хоол бүрд тодорхой хэмжээгээр агуулагддаг усны молекул маань нэмэх, хасах хоёр туйлтай учраас бичил долгионоос болоод хоёр тийш савлан чирэх хөдөлгөөнд орохдоо бие биетэйгээ мөргөлдөн халдаг. Шарах шүүгээ хоолыг гаднаас нь халааж болгодог бол бичил долгионы зуух дотроос нь халаадгаараа ялгаатай.

Бичил долгионы зуух ашиглаж байгаа хүнд ямар ч аюулгүй бөгөөд анх хийхдээ зуухнаас бичил долгион гадагш алдагдахгүй байхыг сайтар тооцсон байдаг. Харин хоолоо халаахдаа зориулалтын саванд хийж халаах хэрэгтэй.

2.1. Дараах өгүүлбэрүүдийг тохирох баримттай нь зөв харгалзуулаарай. Нэг баримтад хэдэн ч өгүүлбэр багтаж болох ба зарим баримтад харгалзах жишээ байхгүй ч байж болно.

- | | |
|---|-------------------------------|
| a. Бичил долгионы зуухан дотор байдаг долгион нь нүдэнд харагддаггүй 2500 мегагерц орчим давтамжтай. | 1. мэдээлэл лавлагааны баримт |
| b. Өөрөөр хэлбэл ирж, буцаад байгаа долгионууд хоорондоо давхцаж хүчтэй долгион үүсгэж хоолыг халаадаг. | 2. учир шалтгааны баримт |
| c. Халаасан хоол хүний биед сайн уу, муу юу? | 3. тоон баримт |
| d. Бичил долгионы зуухыг зохион бүтээх санааг 1945 онд Percy Spencer хэмээх эрдэмтэн олсон. | 4. таамагласан баримт |
| e. Шарах шүүгээ хоолыг гаднаас нь халааж болгодог бол бичил долгионы зуух дотроос нь халаадгаараа ялгаатай. | |

